



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/197

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах
комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн
байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай (шинэчилсэн найруулга) хуулийн 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 153 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын дүрэм”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, 2 дугаар зүйлийн 2.3 болон 2.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хөдөлмөрийн тухай (шинэчилсэн найруулга) хууль 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдсөнтэй холбогдуулан хөдөлмөрийн эрхийн маргааныг хянан шийдвэрлэх эрх, үүрэг бүхий Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах орон тооны бус комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Ажил олгогчийн төлөөлөгч:

Гишүүн:

Б.Хүсэлт

Хууль, эрх зүй, дүрмийн
боловсруулалтын газрын ахлах
мэргэжилтэн

П.Батбаяр

Хууль, эрх зүй, дүрмийн
боловсруулалтын газрын хуулийн
мэргэжилтэн

Б.Цолмонгэрэл

Хууль, эрх зүй, дүрмийн
боловсруулалтын газрын дотоод
ажил хариуцсан мэргэжилтэн

Ажилтны төлөөлөгч:

Гишүүн:

Д.Атарсайхан

Холбоо, навигаци ажиглалтын
албаны үйлдвэрчний эвлэлийн
хорооны дарга

Я.Сайнжаргал

Нисэхийн мэдээлэл үйлчилгээний
албаны хуульч

Г.Одбаяр

Иргэний нисэхийн ерөнхий газрын
үйлдвэрчний эвлэлийн хорооны
тэргүүн

2.Хөдөлмөрийн тухай (шинэчилсэн найруулга) хууль, Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын дүрмийг мөрдөн ажиллаж тайланг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор ажил олгогч болон нийт ажилтнуудад мэдээлж байхыг Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисст даалгасугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны “Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс байгуулах тухай” А/18 дугаартай тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.МӨНХНАСАН